

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-ын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



АУДИТЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

“Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ нь алдагдалтай ажиллаж орон нутгийн төсвөөс авах дэмжлэг жилээс жилд өссөн байна.

Àãóóëà

Тайланг бэлтгэсэн:

Говь-Алтай аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, Тэргүүлэх аудитор
Х.Түвшинбаяр
Утас: 99489309

Аудитын менежер
Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677

Аудитор
Г.Энхдэлгэр
Утас:99002291
Б.Шинэбаяр
Утас: 99540599

2018 оны 9 дүгээр сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70483413, 70484055
дугаарын утас, 70484030
дугаарын факсаар
харилцана уу.

Хаяг:
Говь-Алтай аймаг
Есөнбулаг сум
Баянхайрхан баг

Товчилсон үгийн тайлбар
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт
Үндсэн мэдээлэл

Дэд зорилт-1: “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ нь 1 илүү, 3 сул орон тоотой ажиллаж үйл ажиллагааны төлөвлөгөөг 82 хувьтай биелүүлжээ.

- 1.1 Байгууллагын бүтэц, зохион байгуулалт оновчтой байна.
- 1.2 Үйлдвэрийн лаборант, инженер механик, борлуулалтын бүртгэлийн ажилтны орон тоонд мэргэжлийн ажилтан томилоогүй байна.
- 1.3 Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан баталж ажиллаагүй байна.
- 1.4 Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлын биелэлт 82 хувьтай байна

Дэд зорилт-2: Үйлдвэрийн газар нь цэвэр усаар ард иргэдийг хангаж байгаа хэдий ч алдагдалтай ажиллаж байна.

- 2.1 Санхүүгийн төлөвлөгөө боловсруулж ажилласан хэдий ч борлуулалтын орлого 47.3 сая төгрөгөөр тасарч, 2.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.
- 2.2 Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

Дэд зорилт-3: Хяналт шалгалтын үр өгөөж тухайн байгууллагад бий болсон байна.

- 3.1 Дотоод хяналт хийгдэж байгаа боловч “Дотоод хяналт шалгалт хийх журам”-ыг баталж үйл ажиллагааг илүү сайжруулах шаардлагатай байна.
- 3.2 Хөндлөнгийн хяналтын байгууллагын зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлснээр үйл ажиллагаанд дэвшилттэй тал бий болжээ.
- 3.3 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил 2018 онд арилсан байна.

Холбогдох байгууллагын санал
Саналын хариу тайлбар
Хавсралтууд

Товчилсон үгийн жагсаалт

ҮАГ	Үндэсний аудитын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ГАА	Говь-Алтай аймаг
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ГА	Гүйцэтгэлийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
УОО	Урьдчилж орсон орлого
АДБАЧ	Ардын дуу бүжгийн алтай чуулга
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЭМ	Түүхий эд материал
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НББ	Нягтлан бодох бүртгэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-ын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

“Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-ын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах үндсэн чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ нь хууль тогтоомжийн дагуу үр нөлөөтэй үйл ажиллагаа явуулж байна уу?
- Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байна уу?
- Хяналт үр дүнтэй хийгдэж, үр өгөөж бий болсон уу?

Аудитын хамарсан хүрээ

Аудитаар “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-ын 2017 оны үйл ажиллагаа хамрагдлаа. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-ын 2016, 2017 оны үйл ажиллагааг хамруулахаар тусгасан боловч тус байгууллагын 2015, 2016 оны баримт материал цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа бөгөөд Цагдаагийн газраас мөрдөн шалгах ажиллагаа хийгдэж байгаа учраас баримт материалыг манай байгууллагад ирүүлэх боломжгүйгээ албан тоотоор мэдэгдсэн тул “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-ын 2017 оны үйл ажиллагааг бүрэн, биет тооллоготой холбоотойгоор 2018 оны эхний хагас жилийн үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэлийг хамруулж үзлээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа. Үүнд:

- Байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг үзэж, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан эсэх, ажилтнууд ажлын байрны тодорхойлолтод нийцсэн эсэхийг үзлээ.
- Үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөж хэрэгжүүлж буй эсэхийг шалгалаа.
- Орлого, зарлагыг бодитой төлөвлөж, хэрэгжүүлсэн эсэхийг шалгалаа.
- Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг шалгалаа.
- Үндсэн хөрөнгө болон бараа материалд биет тооллого хийж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг үзлээ.
- Дотоод хяналтын ажлыг үнэлсэн.
- Хөндөлөнгийн хяналт шалгалтын байгууллагын шийдвэрийн биелэлтийг шалгалаа.
- Шилэн дансны тухай хуулийн дагуу байршуулсан мэдээллийг үзлээ.

Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Аудитад хамрагдсан хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрхийн акт, баримт бичгийг аудитын шалгуур болгон ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэнд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитыг хийсэн багийн бүрэлдэхүүн

Тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр аудитыг удирдан зохион байгуулж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг явцын болон чанарын хяналт тавьж стандартыг хангуулан, I багийн аудитор Г.Энхдэлгэр, Б.Шинэбаяр нар 2018 оны 6 дугаар сарын 21-ний өдрөөс 8 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж тайлангийн төслийг хүргүүлэн, 2018 оны 9 сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажууллаа.

Аудит хийхэд учирсан бэрхшээл

Хөрөнгө, бараа материалын дутагдал, давхардлыг тулгах гэсэн боловч баримт материал хязгаарлагдмал байлаа.

Үндсэн мэдээлэл

Аймгийн ИТХ-ын 2014 оны 38 дугаар тогтоолоор тус байгууллага нь “Эрүүл ус” ОНӨААТҮГ нэртэйгээр байгуулагдан 2014 оны 03 дугаар сарын 28-ны өдөр улсын бүртгэлд 000130639 гэсэн гэрчилгээний дугаартайгаар бүртгэгдэж 2015 оны 02 дугаар сараас эхлэн ард иргэддээ “Цэвэр ус” нэртэй 18.9 литрийн торхтой усыг 500 төгрөгөөр түгээж, ундны усаар хангаж эхэлсэн байна.

Тус байгууллага нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар сарын 07 өдрийн 75 дугаар тогтоолоор нэршил өөрчлөн “Гэгээн нуур-Цэвэр ус” ОНӨААТҮГ болжээ. Уг тогтоолын 1-р хавсралтаар “Гэгээн нуур-Цэвэр ус” ОНӨААТҮГ-ын дүрмийг, 2-р хавсралтаар бүтэц зохион байгуулалтыг, 3-р хавсралтаар орон тооны бүрэлдэхүүнийг, 4-р хавсралтаар цалингийн шатлал зэрэглэлийг шинэчлэн тогжоожээ.

“Гэгээн нуур Цэвэр ус” ОНӨААТҮГ нь Борлуулалтын хэсэг, Үйлдвэрийн хэсэг гэсэн зохион байгуулалтын 2 бүтэцтэй бөгөөд батлагдсан орон тоо 24 байна.

Тус цэвэр усны үйлдвэр нь аймгийн төв Есөнбулаг сумаас 48 км, Тайшир сумын төвөөс 4 км зайд Завхан голын ай сав газарт байрлаж, 90 метрийн гүнтэй хоёр худаг гаргаж,

цэвэршүүлсэн ус үйлдвэрлэх иж бүрэн дамжлага бүхий үйлдвэрийг байгуулсан байна. Аймгийн төвд Баянхайрхан, Баяншанд, Индэрт, Жаргалант, Түмэн багуудад нийт 8 ус түгээх цэг байгаагаас 6 цэгээс түгээлт хийн ажиллаж байна.

“Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ нь 1 илүү, 3 сул орон тоотой ажиллаж үйл ажиллагааны төлөвлөгөөг 82 хувьтай биелүүлжээ.

1.1. Байгууллагын бүтэц зохион байгуулалт оновчтой байна.

“Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар сарын 07 өдрийн 75 дугаар тогтоолын дагуу борлуулалтын болон үйлдвэрийн гэсэн 2 хэсэгтэй ажиллаж байна. Тус тогтоолын 3 дугаар хавсралтаар “Гэгээн нуур-Цэвэр ус” ОНӨААТҮГ-ын бүрэлдэхүүн, орон тооны схем батлагджээ. Уг тогтоолоор захирал, нягтлан бодогч, борлуулалтын менежер болон борлуулалтын хэсэг 7, үйлдвэрийн хэсэг 14, нийт 24 орон тоогоор баталсан байна. Ажиллаж буй боловсон хүчин нь батлагдсан орон тоотой нийцтэй байгаа эсэхийг судлахад борлуулалтын бүртгэлийн ажилтан, үйлдвэрийн лаборант, инженер механик гэсэн 3 орон тоо сул байна. Үйлдвэрийн цахилгаанчинг гэрээт ажилтнаар гүйцэтгүүлж байна. Орон тоонд батлагдаагүй боловч зайлшгүй шаардлагаар үйлдвэрт үйлчлэгч авч ажиллуулж байна.

Үйл ажиллагаанаас үзэхэд борлуулалтын бүртгэлийн ажилтан байх шаардлага байхгүй байна. Харин лаборант, инженер механик байх шаардлагатай боловч орон тоо сул байна. Харин үйлдвэрийн эрүүл ахуйн шаардлага хангах талаас үйлдвэрт үйлчлэгч байх зайлшгүй шаардлагатай хэдий ч үндсэн орон тоонд батлагдаагүй байна. /Хавсралт №1/

Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Байгууллагын бүтэц, орон тоо, гүйцэтгэл

Хүснэгт №1

ДД	Нэгж	Албан тушаал	Батлагдсан орон тоо	Тухайн орон тоонд ажиллаж буй хүний тоо
1		Захирал	1	1
2		Нягтлан бодогч	1	1
3		Борлуулалтын менежер	1	1
4	Борлуулалтын хэсэг	Борлуулалтын бүртгэлийн ажилтан	1	
5		Бичиг хэргийн эрхлэгч, нярав	1	1
6		Аймгийн төвд ус түгээгч жолооч	2	2
7		Ачигч буулгагч	3	3
8	Үйлдвэрийн хэсэг	Үйлдвэрийн технологич эрүүл ахуйч	1	1
9		Инженер механик /ХАБ-ыг хариуцна/	1	
10		Үйлдвэрийн цахилгаанчин	1	1 /гэрээт ажилтан/
11		Үйлдвэрийн лаборант	1	
12		Үйлдвэрийн нярав	1	1
13		Үйлдвэрийн савлах цехийн ажилтан	5	5
14		Ус тээврийн жолооч	2	2
15		Ачигч буулгагч	2	2
16		Үйлчлэгч	0	1
Нийт			24	22

Хүнсний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт¹, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт², 5.1.2 дахь заалт³, 5.1.3 дахь заалт⁴-уудад бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ аюулгүй байдлыг хариуцах, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаа, баримтад тулгуурлан тодорхойлох гэж заасан. Бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зорилгоор аймгийн МХГ-ын даргатай “Хамтран ажиллах гэрээ” байгуулжээ. Гэрээнд сар тутамд шинжилгээний дээжийг шинжлүүлэхээр тусгаж, гэрээний хавсралтаар хуваарь баталжээ. “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ нь 2017 оны 2 болон 3 сард шинжилгээ хийлгэсэн байна. Шинжилгээгээр чанарын шаардлага хангасан дүгнэлт гарсан байна. Гэвч гэрээний хэрэгжилт хангалтгүй бөгөөд биелэлтийг тооцоогүй байна.

Харин биет тооллогоор үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 6 нэр төрлийн 3,431.6 мянган төгрөгийн лабораторийн багаж тоног төхөөрөмжийг үйлдвэр нээгдсэн хугацаанаас хойш огт ашиглаагүй шинээрээ байна. Мөн 428.9 мянган төгрөгийн лабораторийн багажийг мэргэжлийн хяналтын газарт ашиглуулж байгаа гэсэн тайлбар өгсөн. Лабораторийг нээгээгүйгээс нийт 3,860.5 мянган төгрөгийн хөрөнгө ашиглалтгүй байгаа бөгөөд батлагдсан орон тоонд лаборант байгаа тул үйлдвэрийн байрандаа лабораторитой болж, өдөр тутам тавих хяналтаа сайжруулан ажиллах нь зүйтэй байна.

Дээрхээс үзэхэд бүтэц зохион байгуулалт оновчтой байна. Харин батлагдсан орон тоог дахин харж, үр ашигтай байдлаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.

1.2. Үйлдвэрийн лаборант, инженер механик, борлуулалтын бүртгэлийн ажилтны орон тоонд мэргэжлийн ажилтан томилоогүй байна.

Үйлдвэрийн хэсэгт үйлдвэрийн лаборант, инженер механикийн орон тоонд мэргэжлийн боловсон хүчин томилоогүй сул байна. Үйлдвэрийн цахилгаанчны орон тоонд үндсэн ажилтан томилоогүй, гэрээгээр ажилтан ажиллуулж байна.

Анх үйлдвэрийг байгуулахдаа мэргэжлийн лабораторитой, лаборанттай байхаар төлөвлөж лабораторийн тоног төхөөрөмж бэлтгэж, бүтэц орон тоонд лаборантыг баталжээ. Гэтэл лабораторийн өрөө тохижуулах хөрөнгө мөнгө байхгүй гэсэн шалтгаанаар лабораторийг тохижуулаагүй байна. Тус байгууллага нь усны шинжилгээг МХГ-т 2 удаа хийлгэж 2017 онд 49.0 мянган төгрөг үйлчилгээний төлбөрт төлсөн байна.

Батлагдсан орон тоонд багтаан мэргэжлийн инженер механик томилох нь үйлдвэрийн эвдрэл гэмтлийг засах, үйл ажиллагааг жигд явуулахад дэмжлэг болох юм.

Үйлдвэрийн ажиллах орчин нөхцөл хэвийн. Аймгийн төвд “Улаан загалмайн хороо”-ны түрээсийн байранд гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байна.

1.3. Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан баталж ажиллаагүй байна.

¹ Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлж, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

² хүнсний сүлжээний бүх үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах;

³ хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ аюулгүй байдлыг хариуцах;

⁴ хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаа, баримтад тулгуурлан тодорхойлох;

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 75 дугаар тогтоолоор батлагдсан "Гэгээн нуур" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.5 дахь заалт⁵-д бүтэц, зохион байгуулалтын хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг баталж, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэхээр заасан байна. Аудитаар үйлдвэрийн газрын дүрмийн дагуу ажлын байрны тодорхойлолтыг баталсан эсэхийг үзэхэд ажлын байрны тодорхойлолтыг боловсруулаагүй, батлаагүй байна.

Иймд ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан баталж, цаашид түүнд нийцүүлэн ажилтанг томилж, ажлын байрны чиг үүргийг тодорхойлох нь зүйтэй байна.

Байгууллагын удирдлага аймгийн Засаг даргатай үр дүнгийн гэрээ байгуулан ажилласан байна. Үр дүнгийн гэрээнд 21 бүтээгдэхүүн үйлчилгээ тусган, биелэлтийг хангуулан ажиллаж 87.3 хувиар "В" буюу "Сайн" үнэлэгджээ.

Байгууллагын 20 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна. Хөдөлмөрийн гэрээг хугацаагүй байгуулсан бөгөөд гэрээг дүгнэж, урамшуулал олгоогүй байна.


1.4. Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлын биелэлт 82 хувьтай байна.

Байгууллагын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 чиглэлээр 22 ажил үйлчилгээ тусган баталжээ. Төлөвлөгөөнд тусгасан ажлуудаас дараах ажлууд хийгдээгүй байна. Үүнд:

- Олон нийтийг хамарсан томоохон арга хэмжээг байгууллагаасаа санаачлан зохион байгуулах
- Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулж, ажлын байрны тодорхойлолтыг батлах
- Цэвэр усны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор 1.5 литрийн савлагаатай ус үйлдвэрлэж эхлэх.
- Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн оруулна.

Дээр тусгагдсан ажлаас бусад ажил хангалттай сайн биелсэн байна. /Хавсралт №2/

Борлуулалтыг графикаар харуулбал: /График №1/



Графикаас харахад цэвэр усны борлуулалт хэвийн, торхны борлуулалтын тухайд шинэ торх үйлдвэрлэсэн үед борлуулалт сайн байна.

⁵ Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн баталсан хурлын шийдвэрээр баталсан удирдлагын бүтэц, зохион байгуулалтын хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг баталж, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлөх

Хоёр. Үйлдвэрийн газар нь цэвэр усаар ард иргэдийг хангаж байгаа хэдий ч алдагдалтай ажиллаж байна.

2.1. Санхүүгийн төлөвлөгөө боловсруулж ажилласан хэдий ч борлуулалтын орлого 47.3 сая төгрөгөөр тасарч, 2.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 “З”⁶ дахь заалтад үйлдвэрийн газрын захирлын эрх үүрэгт үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангахаар зааж өгсөн. Мөн байгууллагын захирлын 2014 оны А/8 тоот тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.7.1.1 дэх заалт⁷-д бизнес төлөвлөгөөг жилээр төлөвлөхөөр, 3.7.1.2 дахь заалт⁸-д бизнес төлөвлөгөөг урьд оны 4 дүгээр улиралд багтаан захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсэг боловсруулж батлуулахаар заасан байна. Ажлын хэсэг байгуулж боловсруулаагүй боловч “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-ын 2017 оны орлого, зардлын төлөвлөгөө батлан ажилласан байна. Тус төлөвлөгөөгөөр 366,000.0 ширхэг ус үйлвэрлэхээр байсан боловч иргэдийн эрэлт хэрэгцээ тооцоолсон хэмжээнд хүрээгүй учраас төлөвлөснөөс бага ус үйлдвэрлэж, 135,748.5 мянган төгрөгийн орлоготой ажиллаж 47,251.5 мянган төгрөгөөр борлуулалтын орлого тасарсан байна. /Хавсралт №3/

Орлого зардлын төлөвлөгөөгөөр борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал нь 2 төгрөг 3 мөнгө гэж тооцсон боловч тайлангаар борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал нь 2 төгрөг 51 мөнгө гарсан байна. Орлого зардлын төлөвлөгөөгөөр 375,525.5 мянган төгрөгийн зардал баталсан боловч аудитад ирүүлсэн зардлын задгай тооцоогоор 273,397.6 мянган байна. Иймд орлого зардлын төлөвлөгөөг нарийн гаргаж, гүйцэтгэлийг хангаж ажиллах нь зүйтэй байна.

Тус үйлдвэр нь 50-80 метрийн гүнээс татсан усыг 3 шүүлтүүрээр шүүн цагт 5 тн ус цэвэршүүлэн шүүж 300 торх ус савлах хүчин чадалтай байна. Жилийн дундаж хэмжээг тооцоход 500,000 ширхэг 18.9 литрийн ус савлах хүчин чадалтай. 2017 оны тухайд 253,000 ширхэг ус савласан байна. Аймгийн төвд 6 ус түгээх цэг байнгын ажиллаж борлуулалт хийж байгаа бөгөөд 18.9 литрийн усаар тасрахгүй үйлчилж байна. /Хавсралт №4.1/

Шалгагдагч байгууллага нь борлуулалтын орлогыг түгээгч нараар дансанд тушаалгадаг явдлыг таслан зогсоож, нярав дугаарласан анхан шатны баримтаар өдөр бүр цэгүүдээс орлогыг хураан авч маргааш өглөө нь банкинд тушааж хэвшжээ. Энэ нь мөнгө дутааж үрэгдүүлэх, тооцоо үүсэх эрсдэлээс хамгаалж байна. /Хавсралт №4.2-4.6/

Аудитын тооцоогоор борлуулалтын орлогыг задалж харуулбал:

- 0.5 литрийн ус 35,627 ширхэгийг үйлдвэрлэж, 31,600 ширхэгийг борлуулан 12,600.0 мянган төгрөг
- 18.9 литрийн ус 253,000 ширхэгийг үйлдвэрлэж хорогдлыг тооцон борлуулж 122,862.0 мянган төгрөг

⁶ Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах;

⁷ Үйлдвэрийн газрын эрхэм зорилгод нийцсэн стратеги төлөвлөгөө хэрэгжүүлэх зорилтын хүрээнд үйл ажиллагааны нэгдсэн бизнес төлөвлөгөөг жилээр төлөвлөж бүтээгдэхүүн үйлчилгээ, харилцагч, санхүү, дотоод процесс сургалт хөгжлийн зэрэг бүхий л үйл ажиллагааг хамруулна.

⁸ Бизнес төлөвлөгөөг шинэ оны эхнээс хэрэгжүүлэх бөгөөд үүний тулд боловсруулах, хэлэлцэх, нэгтгэх ажлыг 4-р улирлаас эхлэн захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсэг зохион байгуулж батлуулна.

- Шинэ торх 1302 ширхэгийг 8.0 мянган төгрөгөөр, 50 ширхэгийг 5.0 мянган төгрөгөөр зарж 10,666.0 мянган төгрөг
- Бэлэн бүтээгдэхүүний борлуулалтаас 2,050.0 мянган төгрөг орсон байна.
Зардлын тухайд:
 - Ажилчдад олгосон мөнгө -91,381.7 мянган төгрөг
 - Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн -25,032.8 мянган төгрөг
 - ТЭМ худалдан авахад төлсөн – 102,716.5 мянган төгрөг
 - Ашиглалтын зардалд төлсөн – 25,301.4 мянган төгрөг
 - Түлш, шатахуун, тээврийн хөлс- 47,687.4 мянган төгрөг
 - Татварт төлсөн мөнгө- 10,173.5 мянган төгрөг
 - Бусад зардалд -47,950.6 мянган төгрөг зарцуулсан байна.

Шалгагдагч байгууллага тайлант онд 45,391.4 мянган төгрөгийн шатахуун шууд худалдан авсан байна. Энэ нь ТБОНӨХБАУХАТ хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх заалт⁹-ыг зөрчсөн үйл ажиллагаа болжээ.

2.2. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалт¹⁰-д нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөж ажиллахыг заасан. Аудитаар үүнийг нягтлан үзэхэд шалгагдагч байгууллага Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөн ажиллаж байна. Мөн ТЭЗ нь аймгийн хэмжээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах ажлыг зохион байгуулж байна.

Иймд аудитаар байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлэн мөнгөн хөрөнгө, орлого, зардал, үндсэн хөрөнгө, бараа материал, өглөг, авлагыг голчлон үзлээ. Ингэхдээ касс, харилцах, борлуулалтын орлого, цалин хөлсийг байгууллагын 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын баримт материалаас авч ашигласан болно.

Мөнгөн хөрөнгийн талаар:

Тайлант оны эхэнд 1,041.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, 354,129.7 мянган төгрөгийн орлогын гүйлгээ, 354,648.8 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, оны эцэст 522.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Орон нутгийн төсвөөс 202,000.0 мянган төгрөгийн дэмжлэг авч, НДХ-ээс 1,990.2 мянган төгрөгийн тэтгэмж, банкны хүүнд 242.0 мянган төгрөг орж, урьд оны авлагаас 2,799.6 мянган төгрөг барагдсан байна.

Үндсэн хөрөнгийн талаар:

Аудитаар үндсэн хөрөнгө болон бараа материалын үлдэгдэлд биет тооллого хийж, ашиглалтын байдалд хяналт тавьсан. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө акталж, устгаагүй, 4,581.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн. Байгууллагад жилийн эцсээр 1,381,014.6 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа бөгөөд тооллогоор 1,335,978.3 мянган төгрөгийн хөрөнгө тоологдсон. “Dongo Feng” нэртэй 42,655.0 мянган төгрөгийн үнэтэй авто машин

⁹ Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно

¹⁰ Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана

тээврийн хэрэгсэл болон машин тоног төхөөрөмжид адил үнээр бүртгэгдсэн байна. Хөрөнгө бэлтгэсэн үеийн анхан шатны баримт Цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа шалтгааны үлмаас аудитад ирүүлээгүй тул тулган баталгаажуулах боломж хязгаарлагдсан. Үндсэн хөрөнгийн тооллоготой холбоотой дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн тооллогоор 992.4 мянган төгрөгийн хөрөнгө дутагдсан.
- Биет тооллогоор үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 3 нэр төрлийн 1,353.9 мянган төгрөгийн хөрөнгө байгууллагын эзэмшилд байхгүй байсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь заалт¹¹-д эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр зээлдүүлэх, бэлэглэх, барьцаалахыг хориглосон байна. Мөн хуульд эд хөрөнгийг идэж ашигласан болон дутагдуулсан тохиолдолд буруутай этгээдээр төлүүлэхээр заасан. Иймд үндсэн хөрөнгөтэй холбоотой илэрсэн зөрчлүүд нь дээрх хуулийн заалтыг зөрчсөн бөгөөд дутагдсан, байгууллагын эзэмшилд байхгүй байгаа хөрөнгийг төлүүлэх болон, байгууллагын эзэмшилд байршуулах шаардлагатай байна. /Хавсралт №5/

Бүртгэлд 8,269.1 мянган төгрөгийн үнэтэй хийн компрессорыг “РЕТ лонк үлээгч 0,5-1,5” нэрээр зөрүүтэй бүртгэсэн. Жижиг ус болон 18.9 литрийн усны сав үлээгчийн үнийг хөрөнгүүдэд зөрүүтэй нааж кодолсон байна.

Бараа материалын талаар:

Бараа материалын үлдэгдэлд биет тооллого хийж 2018 оны хагас жилээр тайлагнасан үлдэгдэлтэй шахаж тулган баталгаажууллаа. Бараа материалын тайлангаар тайлант онд 137,948.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 81,753.9 мянган төгрөгөөр буурч оны эцэст 162,962.5 мянган төгрөгийн бараа материал үлдэгдэл тайлагнасан байна. 2018 оны эхний хагас жилд бараа материал 91,284.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, 171,454.5 мянган төгрөгөөр буурч, 82,792.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Их хэмжээгээр буурсан шалтгаан нь аймгийн ИТХ-ын шийдвэрийн дагуу 2018 онд 5803 ширхэг 43,165.1 мянган төгрөгийн торх акталж данснаас хассан байна.

Биет тооллогоор дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Ус түгээх цэгүүдэд тоологдсон 1,032.0 мянган төгрөгийн бэлэн бүтээгдэхүүнийг шууд зардалд тайлагнаж бараа материалын тайлангаас хассан байна.
- Бараа материалын тайлангаас 2017 онд 100 ширхэг 400.0 мянган төгрөгийн үнэтэй төмөр суурийг үндэслэлгүйгээр хассан байна.
- Бараа материалын тооллогоор 210.6 мянган төгрөгийн материал илүүдсэн.
- Бараа материалын тооллогоор 892.6 мянган төгрөгийн материал дутсан.
- Бараа материалын тооллогоор тоологдоогүй 10,031.5 мянган төгрөгийн материал, 17,927.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл данс бүртгэлд байсан. Үүнийг нярав, нягтлан бодогч тухайн үед данснаас хасаагүй бөгөөд 2015-2017 онд ашиглалтанд тавьж олгосон материал гэж тайлбарласан. Үүнээс 17,927.0 мянган төгрөгийн сэлбэгийг аудитын явцад данс бүртгэлээс хассан байна.

Тооллогоор дутагдсан, байгууллагын эзэмшилд байхгүй байсан бараа материалыг төлүүлж, илүүдсэн болон үндэслэлгүй бүртгэлээс хассан бараа материалыг данс бүртгэлд тусгах шийдвэр гаргалаа. Харин аудитын явцад данснаас хассан, мөн өмнө онд зарцуулагдаж, автомашинд сэлбэгдсэн бараа материал сэлбэг хэрэгслийг анхан шатны

¹¹ Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно


баримттай тулган нягтлаж холбогдох шийдвэрийг гаргах нь зүйтэй бөгөөд зөрчлийг давтан гаргахгүй байхаар ажиллах шаардлагатай байна. /Хавсралт №6.1-6.6/

Бараа материалын тооллогоор “Эрүүл ус” гэсэн нэртэй 18.9 литр болон 0.5 литрийн 39,628 ширхэг 15,788.1 мянган төгрөгийн үнэтэй шошго тоологдсон. Энэ нь аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 75 дугаар тогтоол гарч “Эрүүл ус” ОНӨААТҮГ-ын нэрийг өөрчлөн “Гэгээн нуур-Цэвэр ус” ОНӨААТҮГ нэртэй болгосноор эдгээр шошгыг ашиглах боломжгүй болгож төсвийг үр ашиггүй үрэх үндэслэл болжээ. “Эрүүл ус” нэртэй шошгоны үнийн үлдэгдэл төлбөр 7,464.0 мянган төгрөгийг барагдуулаагүй байгаа бөгөөд, ажил гүйцэтгэгч тал шүүхэд хандан шийдвэрлүүлжээ. Шүүхийн 2018 оны 6 сарын 20-ны өдрийн шийдвэрээр уг төлбөрийг “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-аар төлүүлэхээр шийдвэр гарсан байна. Харин “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ нь давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан байна.

Авлагын талаар:

Тухайн байгууллага нь оны эхэнд 120,877.0 мянган төгрөгийн авлагатай байсан бөгөөд тайлант онд 1,482.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, 7,091.0 мянган төгрөгөөр буурч оны эцэст аж ахуй нэгж байгууллагууд, ус түгээх цэгийн түгээгчээр ажиллаж байсан иргэн, дэлгүүр зэрэг 37 нэгжтэй холбоотой 114,990.6 мянган төгрөгийн он дамжсан авлагатай байна. Үүнээс 6,308.3 мянган төгрөг нь НӨАТ-ын авлага байна.

Аудитаар авлагын тооцоотой байгууллага иргэнтэй тулгалт хийсэн бөгөөд эдгээрээс



хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа болон хаяг утас тодорхойгүй байгууллага, иргэнийг орхиж, үлдсэн 22 байгууллага, иргэнийг хамарч тулгалт хийлээ. Тулгалтын үр дүнг харуулбал дараах байдалтай байна. /График №3/

Хууль хяналтын байгууллагаар шалгагдаж

байгаа 1 иргэнтэй холбоотой 47,357.7 мянган төгрөгийн авлага нь нийт авлагын 41 хувийг эзэлж байна. Мөн 4 иргэн тооцоо нийлсэн акт үйлдээгүй ч 3,000.3 мянган төгрөгийн авлагыг хүлээн зөвшөөрч байна. Эдгээр дэлгүүр болон иргэнтэй тооцоо нийлсэн акт яаралтай үйлдэн, авлага баталгаажуулж, барагдуулах боломжтой байна. /Хавсралт №7/

Харин тооцоо нийлж баримтжуулаагүй, тооцоог огт хүлээн зөвшөөрөхгүй байгаа, эзэн холбогдогчийг нь тодруулж чадахгүй байгаа нийт 50,504.8 мянган төгрөгийн авлага байна. Эдгээрийг хууль хяналтын байгууллагад өгч шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг зөвлөж байна.

Байгууллага нь 2017 онд нэмж борлуулалтын авлага үүсгээгүй байна. Мөн он дамжсан авлагуудыг барагдуулахаар аймгийн ЗДТГ-ын хууль зүйн хэлтэстэй хамтран ажиллаж 9 дэлгүүртэй холбоотой 2,799.6 мянган төгрөгийн барагдуулж ажиллажээ.

Өглөгийн талаар:

Санхүүгийн тайланд тусгасан өглөгийг задалж тулгалаа. Оны эхэнд бүртгэлтэй байсан 93,291.7 мянган төгрөгийн өглөг оны эцэст буурч 55,495.0 мянган төгрөг болсон байна. Үүнийг задлан харуулбал дараах байдалтай байна.

Өглөгийн дэлгэрэнгүй судалгаа

/Хүснэгт №2/
Мянган төгрөг

дд	Байгууллагын нэр	Өглөг			Барагдаагүй шалтгаан		
		Үүссэн он	Үүссэн шалтгаан	Мөнгөн дүн	Тооцоо нийлж баталгаажуулсан	Авлагатай байгууллага нь аудитлагдсан СТ-нд авлага тусгаагүй	Хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэх шатанд
1	Ойн анги	2015	Мод тарихаар авсан	5,000.0		5,000.0	
2	SMGT	2015	То/тө-ийн өглөг	2,000.0	2,000.0		
3	Агуулах түрээс	2016	Агуулахын түрээс	7,200.0			7,200.0
4	“Сэнгүн билгэ” ХХК	2016	То/тө-ийн өглөг	40,000.0			40,000.0
5	Алтай чуулга	2017	Халаалтын өр /түрээс/	1,185.5		1,185.5	
6	Хамтын сан	2017	Хамтын сан	30.0	30.0		
7	Аудитын газар	2017	УОО	79.5	79.5		
	Нийт			55,495.0	2,109.5	6,185.5	47,200.0

Тайлант онд 37,796.7 мянган төгрөгийн өглөгийг барагдуулсан байна. Дээрх өглөгийн 85 хувь нь хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх шатандаа байна. Үүнд:

- Ш.Галбаатарын эзэмшлийн 420 метр квадрат агуулахыг 2015 онд гэрээ байгуулан сарын 900.0 мянган төгрөгөөр түрээсэлсэн байна. Уг түрээсийн төлбөрийн үлдэгдэл 7,200.0 мянган төгрөгийг төлөөгүй хэмээн Ш.Галбаатар шүүхэд гомдол гаргажээ. Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 6 сарын 20-ны өдрийн шийдвэрээр “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-аар 7,200.0 мянган төгрөг төлүүлэхээр гарсан байна. “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ нь давж заалдах шатны шүүхэд гомдол мэдүүлсэн байна.
- “Сэнгүн билгэ” ХХК-тай 2016 онд байгуулсан тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээний үлдэгдэл төлбөр 40,000.0 мянган төгрөгийн тооцоотой хэмээн тус компани алданги 20,000.0 мянган төгрөгийн хамт шүүхэд гомдол гарган нэхэмжилжээ. Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 6 сарын 20-ны өдрийн шийдвэрээр “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-аар гэрээний үлдэгдэл төлбөр 40,000.0 мянган төгрөг, алданги 20,000.0 мянган төгрөг, нийт 60,000.0 мянган төгрөг төлүүлэхээр гарсан байна. “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ нь мөн давж заалдах шатны шүүхэд гомдол мэдүүлсэн байна.

Харин “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ нь Сум дундын ойн анги болон АДБАЧ-д өгөхөөр 6,185.5 мянган төгрөгийн өглөгийг бүртгэсэн байна. Гэвч тооцоотой байгууллага болох Сум дундын ойн анги болон АДБАЧ-ын аудит хийгдсэн санхүүгийн тайланд авлагаар тусгагдаагүй байна. /Хавсралт №7/

Мөн иргэн Б.Буяншигтэй 2016 онд байгуулсан гэрээний дагуу “Эрүүл ус” нэртэй шошгоны үнийн үлдэгдэл төлбөр 7,464.0 мянган төгрөгийн өр гарч, иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлүүлсэн байна. Шүүхийн шийдвэр 2018 оны 6 сарын 20-ны өдөр гарч

уг төлбөрийг “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-аар төлүүлэхээр шийдвэрлэжээ. Уг өглөг нь шалгагдагч байгууллагын данс бүртгэлд тусгагдаагүй байна.

Шатахуун зарцуулалтын талаар:

Шатахууны тооцоог машин бүрээр шахаж тооцоход үйлдвэр аймгийн төвийн хооронд ус тээвэрт явдаг машинуудын жолоочийн тооцооны хуудсыг спидометрын заалтгүйгээр бодож 37,239.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Засгийн газрын 2002 оны 11 дүгээр тогтоолын “б” заалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2002 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн Санхүү эдийн засгийн сайд, ҮСГ-ын даргын дугаар 171/111 дугаар тушаалаар батлагдсан маягт зааврын дагуу анхан шатны бүртгэлийг хөтлөөгүй байна.

Байгууллагын удирдлага шатахууны хяналтыг сайжруулах зорилгоор 2016 болон 2017 онд тооцоололд үндэслэл шатахуун зарцуулалтын норм тогтоосон байна. Хэдийгээр норм тогтоож, баримталж ажилласан хэдий ч батлагдсан маягтын дагуу жолоочийн тооцоог бодож хэвших нь зүйтэй байна.

Гурав. Хяналт шалгалтын үр өгөөж тухайн байгууллагад бий болсон байна.

3.1. Дотоод хяналт хийгдэж байгаа боловч “Дотоод хяналт шалгалт хийх журам”-ыг баталж үйл ажиллагааг илүү сайжруулах шаардлагатай байна.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2016 оны 75 дугаар тогтоолоор батлагдсан "Гэгээн нуур" ОНӨААТҮГ-ын дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт¹²-д үйлдвэрийн газар үндсэн болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын бүтэц, ажиллах журмыг захирал батална гэж заасан. Мөн Засгийн газрын 2011 оны 311-р тогтоол "Аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын дагуу дотоод хяналтыг хариуцсан ажилтанг томилж, хяналт хийх журмыг баталсан эсэх, дотоод хяналтын ажлын төлөвлөгөө, тайлан, үр дүнг судаллаа. Үйлдвэрийн газрын захирал “Дотоод хяналтын ажиллах журам”-ыг баталж мөрдүүлээгүй байна. Харин дотоод хяналт хариуцсан ажилтнаар борлуулалтын менежерийг томилсон байна.

Тайлант онд дотоод хяналтын ажлын төлөвлөгөө батлуулж ажилласан бөгөөд төлөвлөгөөнд 74 нэгж хяналт тусгасан байна. Дотоод хяналтын ажлын тайлан бичсэн боловч хангалтгүй байна. /Хавсралт №8.1-8.2/

Дотоод хяналтаар 5000 ширхэг торхны дутагдал болон машиг тоног төхөөрөмжинд давхар бүртгэгдсэн 42,655.0 мянган төгрөгийн автомашиныг илрүүлж холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлдэг байснаас байгууллагын төсөв хөрөнгө болон ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотойгоор маргаан үүсч хууль хяналтын байгууллагаар шийдвэрлэгдэж байна. Тэдгээрээс 3 харилцагчийн гомдлын улмаас иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр гарсан байна. Уг шийдвэрийн дагуу 2018 онд 722.5 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамж төлсөн байна. /Хавсралт №8-3/

3.2. Хөндлөнгийн хяналтын байгууллагын зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлснээр үйл ажиллагаанд дэвшилттэй тал бий болжээ.

¹² Үйлдвэрийн газар үндсэн болон санхүүгийн үйл ажиллагааг хянах дотоод хяналттай байна. Дотоод хяналтын бүтэц, ажиллах журмыг захирал батална

Төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын талаар:

“Гэгээн нуур Цэвэр ус” ОНӨААТҮГ-ыг үүсгэн байгуулсан хугацаанаас хойш Төрийн аудитын байгууллага 2014, 2015, 2017 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийсэн байна. Аудитын шийдвэрийг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд 2015 онд тогтоогдсон дараах 3 шийдвэр хэрэгжээгүй байна. Үүнд:

- Анхан шатны баримтгүй 30,054.8 мянган төгрөгийн гүйлгээг хийсэн байна.
- Гэрээт ажиллагсадын цалин 19,702.5 мянган төгрөгөөс 1,970.3 мянган төгрөгийн цалингийн ашиг суутгасан боловч татварт шилжүүлээгүй байна.
- Ойн ангиас мод тарихад зориулан 5000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон боловч одоог хүртэл уг мөнгөөр ажлыг хийж гүйцэтгээгүй байна.

Анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн зөрчилд эрүүгийн хэрэг үүсгэсэн боловч, Нийслэлийн Прокурорын газрын прокурорын 2017 оны 11 сард гарсан тогтоолоор эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож, иргэний журмаар шүүхэд шийдвэрлүүлэхийг зөвшөөрсөн байна. Гэтэл одоог хүртэл уг зөрчил иргэний журмаар шүүхэд гомдол мэдүүлээгүй байна.

Ойн ангиас мод тарихад зориулан 5,000.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон боловч ажил хийгдээгүй зөрчлийн тухайд тус байгууллага өглөгөөр тусган тайлагнажээ. Зөрчил арилаагүй байна.

Харин “Гэгээн нуур Цэвэр ус” ОНӨААТҮГ-ын 2017 оны санхүү тайлангийн аудитаар нийт 429,744.2 мянган төгрөгийн 25 төрлийн зөрчил илэрч 2,900.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 426,380.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 463.6 мянган төгрөгийн залруулга хийсэн байна. Аудитын шийдвэрийг 2018 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор хэрэгжүүлж, биелэлтийг ирүүлэхээр байжээ. Тус хугацаанд төлбөрийн актаас 2,465.3 мянган төгрөгийг хэрэгжүүлсэн байна. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгах талаар үйл ажиллагаандаа мөрдлөг болгож албан шаардлагаар хүргүүлсэн 216,188.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгаж, давтан гаргаагүй байна. Аудитаар өгсөн шийдвэрийн биелэлтийг хавсралтаар харуулав. /Хавсралт №9.1/

Хэрэгжээгүй 213,092.5 мянган төгрөгийн шийдвэрийн 73.6 хувийг он дамнасан өглөг, авлага эзэлж байна. Авлагыг барагдуулах талаар ЗДТГ-ын хууль эрх зүйн хэлтэстэй хамтарч ажил зохион байгуулсан ба тооцоо нийлсэн акт үйлдэж, баталгаажуулах ажил хийгдэж байна. Гэвч уг арга хэмжээ нь бүх тооцоотой байгууллага иргэнийг хамрахгүй байгаа учраас хангалтгүй байна. Өглөгийн тухайд хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх шатандаа байна.

Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2¹³-д аудитын шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд эрх бүхий албан тушаалтанд ажлаас халах санал хүргүүлэхээр заасан байдаг. Аудитын явцад шийдвэрийн биелэлтийг тооцоход илэрсэн зөрчлийн 50.4 хувийг арилгаж, он дамнасан өглөг, авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулж байна. Иймд аудитын шийдвэрийг хангуулах талаар дорвитой ажил зохион байгуулж, биелэлтийг хангуулах шаардлагатай.

Мөн санхүүгийн тайлангийн аудитын бичмэл тайланд дараагийн аудитаар үзэх асуудлуудыг тусгаж өгсөн.

Тэдгээрийг дурьдвал дараах байдалтай байна.

¹³ төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд.

Хүснэгт №3

дд	Үзэх асуудал	Гүйцэтгэлийн аудитаар
1	Аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад үндэслэн үзэх	Аудитаар үндсэн хөрөнгө болон бараа материалын үлдэгдэлд биет тооллого хийсэн. Тооллогоор 42,655.0 мянган төгрөгийн үнэтэй автомашин тоологдоогүй. Автомашиныг бэлтгэсэн үеийн баримт материал аудитад хамрагдаагүйгээс тулган баталгаажуулах боломжгүй нөхцөлд хүрсэн.
2	Өглөг, авлагын тулгалт хийх	Авлага, өглөгийг задлан асуулга, ярилцлага хийж, тулган баталгаажуулалт хийсэн.
3	Шатахууны тооцоо хийх	Шатахууны тооцоог машин бүрээр хийсэн. Гэвч ус тээврийн машины жолоочийн тооцоог спидометрийн заалтыг үндэслэлгүйгээр тогтоосон нормыг мөрдөж шатахуун зарцуулсан байна.

МХГ-ын улсын байцаагчийн 2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн дугаар 08-02-034/02/28 тоот зөвлөн туслах үйлчилгээний талаар:

МХГ-ын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн баталсан 2017оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 08/49 дугаар зөвлөн туслах үйлчилгээний хөтөлбөрийн дагуу 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч, Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч нар “Гэгээн нуур Цэвэр ус” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд “Ус рашааны үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас”-аар зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж эрсдлийг үнэлэхэд 129 оноо буюу 18.5%-аар бага эрсдэлтэй үнэлэгдсэн байна. Зөвлөн туслах үйлчилгээний явцад 15 нэр бүхий зөрчил илэрсэн бөгөөд цаашид арга хэмжээ авч, хэрэгжүүлж ажиллахыг зөвлөсөн байна. Нэр бүхий 15 зөрчлөөс үйлдвэрийн тоног төхөөрөмжтэй хэсэгт ажилладаг ажилчдад сонсголын чихэвч хэрэгслээр хангах, ус түгээх цэгүүдийн түгээгч нарыг нийгмийн даатгалд бүрэн хамруулах гэсэн заалтуудыг хангаж ажиллаагүй байна. Хяналт шалгалтаар өгсөн бусад зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилласан байна. /Хавсралт№9.2/

3.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил 2018 онд арилсан байна.

Байгууллагын 2017 оны төсвийн мэдээллийг “Шилэн дансны тухай” хуульд нийцүүлэн, хуульд заасан хугацаанд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх тухай үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгасан байсан. 2017 онд шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй байсан бөгөөд төсөв гүйцэтгэлийн мэдээлэл 48, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын мэдээлэл 39, бусад мэдээлэл 61 нийт 148 мэдээлэл оруулах ёстой байснаас хугацаандаа оруулсан 41, хугацаа хоцорсон 101 байна. /Хавсралт №10.1/

Харин 2018 оны 07 дугаар сарын байдлаар шилэн дансны хэрэгжилтийг авч үзэхэд төсөв гүйцэтгэлийн мэдээлэл 23, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын мэдээлэл 23, бусад мэдээлэл 36 нийт 82 мэдээлэл оруулсан байна. Үүнээс хугацаандаа оруулсан 73, хугацаа хоцорсон 9 мэдээлэл байна. /Хавсралт №10.2/

ИЛРҮҮЛЭЛТ:

1. Ажилтнуудын тухайн ажлын байранд мөрдөх ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж батлаагүй байна.

2. Биет тооллого хийхэд "Эрүүл ус" гэсэн нэртэй 18.9 литр болон 0.5 литрийн усны 15,788.1 мянган төгрөгийн шошгоны үлдэгдэлтэй байна. "Эрүүл ус" ОНӨААТҮГ-ын нэрийг өөрчлөн "Гэгээн нуур-Цэвэр ус" ОНӨААТҮГ болгосноор тус шошгыг ашиглах боломжгүй болгож төсвийг үр ашиггүй зарцуулах үндэслэлийг бүрдүүлжээ.
3. Биет тооллого хийхэд данс бүртгэлд үлдэгдэлтэй 10,031.5 мянган төгрөгийн бараа материал, 17,927.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэлийг тоолуулаагүй. Үүнийг нягтлан бодогч, нярав нар 2015-2016 онуудад ашиглалтанд тавьж олгосон материалыг данс бүртгэлээс тухайн үед хасаагүй гэж тайлбарллаа.
4. Байгууллагын нягтлан бодох бүртгэлд НӨАТ-ын авлагыг эс тооцвол 108,960.3 мянган төгрөгийн авлага тусгагдсанаас тооцоо нийлж баримтжуулаагүй 41,383.0 мянган төгрөгийн, хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх шатандаа байгаа 47,357.7 мянган төгрөгийн, тооцоотой байгууллага нь огт хүлээн зөвшөөрөөгүй 4,829.0 мянган төгрөгийн, эзэн холбогдогч нь тодорхойгүй 4,292.9 мянган төгрөг, хүлээн зөвшөөрсөн боловч барагдуулдаггүй 8,097.4 мянган төгрөгийн авлага байна.
5. Байгууллага нь Сум дундын ойн ангид өгөх 5,000.0 мянган төгрөг, АДБАЧ-д өгөх 1,185.0 төгрөгийн өглөгийг бүртгэсэн байгаа боловч Сум дундын ойн анги болон АДБАЧ санхүүгийн тайландаа авлагаар тусгаагүй байна.
6. Ус түгээх цэгүүдэд тоологдсон 1,032.0 мянган төгрөгийн бэлэн бүтээгдэхүүнийг шууд зардалд тайлагнаж бараа материалын тайлангаас хассан байна.
7. Бараа материалын тайлангаас 2017 онд 100 ширхэг 400.0 мянган төгрөгийн үнэтэй төмөр суурийг үндэслэлгүйгээр хассан байна.
8. Бараа материалын биет тооллогоор 210.6 мянган төгрөгийн материал илүүдсэн.
9. Бараа материалын биет тооллогоор 892.6 мянган төгрөгийн материал дутсан.
10. Үндсэн хөрөнгийн биет тооллогоор 992.4 мянган төгрөгийн хөрөнгө дутагдсан.
11. Тооллогоор үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 3 нэр төрлийн 1,353.9 мянган төгрөгийн хөрөнгө байгууллагад биетээр байсангүй.
12. Тооллого хийх явцад үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 6 нэр төрлийн 3,431.6 мянган төгрөгийн лабораторийн багаж тоног төхөөрөмж үйлдвэр нээгдсэн хугацаанаас хойш огт ашиглалтгүй байна.
13. Тайлант хугацаанд 45,391.4 мянган төгрөгийн шатахуун худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийг баримтлаагүй байна. Мөн уг зөөврийн 2 автомашины тооцоог спидометрийн заалтаар шахаж тооцоогүй байна.
14. Дотоод хяналтын ажиллах журмыг батлаагүй бөгөөд дотоод хяналт шалгалтыг хангалтгүй хийсэн байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын илрүүлэлтэд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Байгууллагын бүтэц, зохион байгуулалт оновчтой байна.
- Үйлдвэрийн лаборант, инженер механик, борлуулалтын бүртгэлийн ажилтны орон тоонд мэргэжлийн ажилтан томилоогүй байна.
- Ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан баталж ажиллаагүй байна.
- Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан ажлын биелэлт 82 хувьтай байна
- Санхүүгийн төлөвлөгөө боловсруулж ажилласан хэдий ч борлуулалтын орлого 47.3 сая төгрөгөөр тасарч, 2.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.
- Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

- Дотоод хяналт хийгдэж байгаа боловч “Дотоод хяналт шалгалт хийх журам”-ыг баталж үйл ажиллагааг илүү сайжруулах шаардлагатай байна.
- Хөндлөнгийн хяналтын байгууллагын зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлснээр үйл ажиллагаанд дэвшилттэй тал бий болжээ.
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил 2018 онд арилсан байна.

Ерөнхий дүгнэлт

“Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ нь алдагдалтай ажиллаж орон нутгийн төсвөөс авах дэмжлэг жилээс жилд өссөн байна.

Дээрх дүгнэлтэнд үндэслээд дараах шийдвэр гаргалаа.

Зөвлөмж:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд:

1. Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулахаар шийдвэр гаргах.

Аймгийн Засаг даргад:

2. Үйлдвэрийн газрын захиралтай байгуулах үр дүнгийн гэрээнд он дамжсан авлагыг барагдуулах талаар тусган гүйцэтгэлийг үнэлэх.

“Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-т:

1. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, баталж, мөрдүүлж ажиллах
2. Өглөг бүртгэсэн 2 байгууллагатай тооцоо нийлж, үр ашигтай байдлаар шийдвэрлэх.
3. Бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого, тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаа, баримтад тулгуурлан тодорхойлох.
4. Цаашид төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах.
5. "Дотоод хяналтын ажиллах журам"-ыг батлан, дотооддоо тавих хяналтыг сайжруулах.

Албан шаардлага:

“Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-т:

1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, бүх автомашинд зарцуулсан шатахууны тооцоог спидометрийн заалтаар бодож хэвших
2. Нягтлан бодох бүртгэлийг аккрузель сууриар хөтөлж, бараа материалын тайланг үнэн зөв илэрхийлэх.

Төлбөрийн акт:

“Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-т:


1. Үндэслэлгүйгээр данс бүртгэлээс хассан болон тооллогоор илүүдсэн 1,642.6 мянган төгрөгийн материалыг орлого авч бүртгэлд тусгах.
2. Тооллогоор дутагдсан 3,238.9 мянган төгрөгийн хөрөнгө, материалыг төлүүлж байгууллагыг хохиролгүй болгох.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР

2018.09.12

Шалгагдагч байгууллагын санал


**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
“ГЭГЭЭН НУУР ЦЭВЭР УС” ОРОН
НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**
091 Говь-Алтай аймаг, Есөнбулаг сум, Ортол баг
E-mail: gegeemnuur@yahoo.com
Утас/Факс: 70-48-49-50

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

2018.08.27 № 09
Тайлбар 2018.08.15 -ны № 120 -т

Санал хүргүүлэх тухай

Тус газрын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд Гүйцэтгэлийн аудит хийж ирүүлсэн аудитын тайлан, дүгнэлт, шийдвэрийн төсөлтэй танилцлаа. Гүйцэтгэлийн аудитаар бидний цаашид анхаарч нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг сайжруулах, ажил гүйлгээ тус бүрийг тухай бүрд нь данс бүртгэлд тусгаж тайлагнах талаар зөвлөмж зөвлөгөө өгч байгаад талархалтай байна.

Танай аудитын тайлан, дүгнэлт, шийдвэрийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна.

1. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээс Эрүүл-Ус ОНӨААТҮГ-ын нэршилийг 2017 оны 01 сарын 01-нээс Гэгээн нуур-Цэвэр ус ОНӨААТҮГ болгосноос шалтгаалан “Эрүүл ус” нэртэй хэвлэгдсэн 15788,1 мянган төгрөгийн үнэ бүхий шошгыг цаашид хэрэглэхгүй болсныг зөрчлөөр тооцсоныг анхаарч үзэх
2. Тус газрын 75-23 ГАУ ус тээврийн машин эвдэрсний улмаас ашиглагдах боломжгүй болж уг машинд 2017 оны 10 дугаар сард 17927,0 мянган төгрөгийн 24 нэрийн запас сэлбэг тавьж их засвар хийснийг 2017 оны тайлан тэнцэлд үнийг нь капиталжуулалгүйгээр дээрх сэлбэгийг Бараа материалд бэлнээр тоолж 2018 оны эхний хагас жилийн тайланд Бараа материалаас хассаныг зөрчлөөр тооцохгүй байхыг хүсч байна.
3. 2015-2016 онуудад ажилтнуудад тавьж олгосон хөдөлмөр хамгааллын хувцасны ашиглагдах хугацаа нь дууссан 3552,8 мянган, ус тээврийн машинуудад олгосон өндөр үнэтэй сэлбэг, аккумуляторуудын үнэ 3945,6 мянган, үйлдвэр-ийн тоног төхөөрөмжинд 3 төрлийн шүүлтүүр тавьсаны 2533,1 мянган нийт 10031,5 мянган төгрөгийн үнэ бүхий дээрх сэлбэг хэрэгсэл, шүүлтүүр, хөдөлмөр хамгааллын хувцасыг бараа материалаас хасалгүйгээр тайлан тэнцэлд тусгасныг энэ оны 09 дүгээр сард байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлж бараа материалаас хасахаар шийдвэрлэснийг харгалзан үзэж зөрчлөөр тооцохгүй байхыг хүсэж байна.

7770028

4. Тус газрын Тайшир дахь Цэвэр усны үйлдвэрийн нярав Н.Дарамдорж нь 2017.04.30-нд 1233 ширхэг 4932,0 мянган төгрөгийн үнэ бүхий төмөр суурийг 2017.05.01-ний үлдэгдэл гаргахдаа 1133 ширхэг байхаар техникийн алдаа гаргасан нь танайхаас аудит хийх хугацаанд хийсэн тооллогоор 100 ширхэг буюу 400,0 мянган төгрөгийн төмөр суурь илүүдсэнээр нотлогдож байгаа тул үүнийг зөрчлөөр тооцохгүй байхыг хүсье.

5. Тус газар нь байгуулагдсан 2014 оноос хойш шатахуун худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТ тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж байсан нь үнэн юм. Зөвхөн 2017 онд гэхэд 45391,4 мянган төгрөгийн шатахууныг Шунхлай Трейд ХХК-наас оны эхэнд аж ахуйн гэрээ байгуулж авсан болно.

Тус ОНӨААТҮГ нь сард дунджаар 3,8 сая төгрөгийн шатахууны худалдан авалт хийж байгаа бөгөөд 2019 оноос эхлэн харьцуулалтын аргаар уг асуудлыг шийдвэрлэх саналтай байгаа учраас 45391,4 мянган төгрөгийг зөрчлөөр тооцохгүй байхыг хүсье.

6. Тус ОНӨААТҮГ нь 2016 онд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан захирлын тушаалаар баталж мөрдөж байгааг Аудитын тайланд дээрх зүйлийг боловсруулж мөрдөөгүйгээр дүгнэснийг зөвшөөрөхгүй байна.

7. Лэгээн нуур цэвэр ус ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэж байгаа 18,9 литрийн 1 торх усны өөрийн өртөг 1300 төгрөг болж /1300-500=800/ -төгрөгийн алдагдалтай байгаа учраас усны үнийг наад зах нь 1000 төгрөг болгох саналыг Аймгийн ИТХ болон Засаг даргад удаа дараа тавьж байгаа боловч нэгэнт гаргасан шийдвэрийг өөрчлөх боломжгүй гэж үнийн асуудлыг шийдвэрлэж өгөхгүй байгаа юм.

Байдал ийм байхад танай аудитын ерөнхий дүгнэлтэнд борлуулалтын орлогоороо зардлаа нөхөж чадахгүйд хүрч Орон нутгийн төсөвт ачаалал учруулж байна гэсэн ерөнхий дүгнэлтийг зөвшөөрөх боломжгүй байна.

8. Гүйцэтгэлийн аудитаар гаргасан танай бусад дүгнэлт, зөвлөмж шийдвэрийг хүлээн зөвшөөрч шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Бидний тавьсан дээрх санал хүсэлтийг зөвлөмж шийдвэртээ харгалзана гэдэгт эргэлзэхгүй байна.

ЗАХИРАЛ

Ж.ГАВАА

Саналын хариу тайлбар

д/д	Ирсэн санал	Хариу тайлбар
1	Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээс “Эрүүл-Ус” ОНӨААТҮГ-ын нэршлийг 2017 оны 01 дүгээр сарын 01-нээс “Гэгээн нуур –Цэвэр ус” ОНӨААТҮГ болгосноос шалтгаалан “Эрүүл ус” нэртэй хэвлэгдсэн 15,788.1 мянган төгрөгийн үнэ бүхий шошгыг цаашид хэрэглэхгүй болсныг зөрчлөөр тооцсоныг анхаарч үзэх	ИТХ-ын тэргүүлэгчдийн шийдвэр нь Төсвийн тухай хуулийн арвилан хэмнэлттэй байх зарчмыг зөрчсөн байсан. Мөн АДБОУС-аар гүйцэтгэлийн аудит нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй байдалд үнэлэлт, дүгнэлт өгдөг. Иймд уг зөрчилд ИТХ болон байгууллагад шийдвэр хүргүүлсэн. Зөрчлөөс хасах үндэслэлгүй байна.
2	Тус газрын ГАУ-75-23 тээврийн машин эвдэрсний улмаас ашиглагдах боломжгүй болж уг машинд 2017 оны 10 дугаар сард 17,927.0 мянган төгрөгийн 24 нэрийн запас сэлбэг тавьж их засвар хийснийг 2017 оны тайлан тэнцэлд үнийг нь капиталжуулалгүйгээр дээрх сэлбэгийг бараа материалд бэлнээр тоолж 2018 оны эхний хагас жилийн тайланд бараа материалын тайлангаас хассаныг зөрчлөөр тооцохгүй байхыг хүсч байна.	Анх аудитад ирүүлсэн 2018 оны 6 сарын 28-ны өдрөөр гаргасан бараа материалын тайлангаар уг 17,927.0 мянган төгрөгийн сэлбэгийг үлдэгдлээр тайлагнасан байсан. Аудитаар биет тооллого хийсний дараа бараа материалаас хассан тул цаашид энэ төрлийн зөрчил гарахгүй байхаас урьдчилан сэргийлж зөрчлөөр авч шийдвэр гаргасан юм.
3	2015-2016 онуудад ажилтнуудад тавьж олгосон хөдөлмөр хамгааллын хувцасны ашиглагдах хугацаа нь дууссан 3,552.8 мянган төгрөг, ус тээврийн машинуудад олгосон өндөр үнэтэй сэлбэг, аккумуляторуудын үнэ 3,945.6 мянган төгрөг, үйлдвэрийн тоног төхөөрөмжид 3 төрлийн шүүлтүүр тавьсаны 2,533.1 мянган төгрөг нийт 10,031.5 мянган төгрөгийн үнэ бүхий дээрх сэлбэг хэрэгсэл, шүүлтүүр, хөдөлмөр хамгааллын хувцсыг бараа материалаас хасалгүйгээр тайлан тэнцэлд тусгасныг энэ оны 09 дүгээр сард байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлж бараа материалаас хасахаар шийдвэрлэснийг харгалзан үзэж зөрчлөөр тооцохгүй байхыг хүсэж байна.	Уг зөрчлийг хүлээн зөвшөөрч засах арга хэмжээг урьдчилан тодорхойлсон байна. Уг дутагдал нь тооллогоор илэрсэн бөгөөд шалгагдагч байгууллагын ажилтнуудын тайлбарыг харгалзан үзэж зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлж байна. Мөн аудитын явцад зөвлөгөө өгч ажилласан болно Байгууллага Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу НББ-ийг аккрузель сууриар хөтлөх ёстой. Иймд саналыг хүлээн авах боломжгүй байна.
4	Тус газрын Тайшир дахь Цэвэр усны үйлдвэрийн нярав Н.Дарамдорж нь 2017 оны 04 сарын 30-нд 1233 ширхэг 4,932.0 мянган төгрөгийн үнэ бүхий төмөр суурийг 2017 оны 05 дугаар сарын 01-ний үлдэгдэл гаргахдаа 1133 ширхэг байхаар техникийн алдаа гаргасан нь танайхаас аудит хийх хугацаанд хийсэн тооллогоор 100 ширхэг буюу 400.0 мянган төгрөгийн төмөр суурь илүүдсэнээр нотлогдож байгаа тул үүнийг зөрчлөөр тооцохгүй байхыг хүсье.	Нягтлан бодох бүртгэл, нярвын тайланд тавих хяналт сул байснаас тайлагналын алдаанаас үүдсэн зөрчил илэрсэн. Иймд “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 дэх заалтын 3 дахь хэсэгт “нэр төрлийн материал үнэ

		бүхий зүйлийн дутагдлыг бусад үнэ бүхий зүйлийн илүүдлээр нэг эд хариуцагчаас гарсан дутагдлыг нөгөө эд хариуцагч дээр гарсан илүүдлээр, хоёр өөр хугацаанд гарсан нэг төрлийн адил үнэтэй зүйлийн дутагдлыг илүүдлээр хаахыг хориглоно. Харин тооллогоор илэрсэн илүүдлийг зохих дансанд орлого болгож илүүдэл гарсан шалтгааныг тогтооно” гэж заасны дагуу зөрчлөөс хасах үндэслэлгүй байна.
5	Тус газар байгуулагдсан 2014 оноос хойш шатахуун худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн холбогдох заалтыг зөрчиж байсан нь үнэн юм. Зөвхөн 2017 он гэхэд 45,391.4 мянган төгрөгийн шатахууныг Шунхлай Трейд ХХК-наас оны эхэнд аж ахуйн гэрээ байгуулж авсан болно. Тус ОНӨААТҮГ нь сард дунджаар 3.8 сая төгрөгийн шатахууны худалдан авалт хийж байгаа бөгөөд 2019 оноос эхлэн харьцуулалтын аргаар уг асуудлыг шийдвэрлэх саналтай байгаа учраас 45,391.4 мянган төгрөгийг зөрчлөөр тооцохгүй байхыг хүсье.	Төрийн аудитын байгууллагаас баталсан төлөвлөгөөнд зардлыг дэд зорилтоор оруулж шатахууны худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулсан эсэхийг үзэхэд тухайн зөрчил илэрсэн. Уг зөрчлийг дур мэдэн хасах боломжгүй юм.
6	Тус ОНӨААТҮГ нь 2016 онд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан захирлын тушаалаар баталж мөрдөж байгааг аудитын тайланд дээрх зүйлийг боловсруулж мөрдөөгүйгээр дүгнэснийг хүлээн зөвшөөрөхгүй байна.	Аудитын явцад хариуцсан ажилтнууд НБББББ-ийг ирүүлээгүй тул тайланд тусгасан. Баримтыг нөхөн авч үзэн ирүүлсэн саналыг хүлээн авч тайланд засвар хийлээ.
7	“Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэж байгаа 18.9 литрийн 1 торх усны өөрийн өртөг 1300 төгрөг болж /1300-500=800/-төгрөгийн алдагдалтай байгаа учраас усны үнийг наад зах нь 1000 төгрөг болгох саналыг аймгийн ИТХ болон Засаг даргад удаа дараа тавьж байгаа боловч нэгэнт гарсан шийдвэрийг өөрчлөх боломжгүй гэж үнийн асуудлыг шийдвэрлэж өгөхгүй байгаа юм. Байдал ийм байхад танай аудитын ерөнхий дүгнэлтэнд борлуулалтын орлогоороо зардлаа нөхөж чадахгүйд хүрч Орон нутгийн төсөвт ачаалал учруулж байна гэсэн ерөнхий дүгнэлтийг зөвшөөрөх боломжгүй байна.	Саналыг хүлээн авч ерөнхий дүгнэлтийг “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ нь алдагдалтай ажиллаж орон нутгийн төсвөөс авах дэмжлэг жилээс жилд өссөн байна” гэж заслаа.

